



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1/204

Бсонбулаг

Малын сэг зэм устгах, орчны  
цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэлийн  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэг, 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.5, 7.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд малын сэг зэмийг устгах, орчны цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.


2. Сумд харьяалах төв суурин газар, улс, аймгийн чанартай авто зам, малын бэлчээр, гол, булаг шандын орчмын үхсэн малын сэг зэмийг цуглуулж, булж устгах, орчны цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэл хийхэд шаардагдах ажиллах хүч, унаа тээвэр шатахуун зэрэг шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж, орон нутгийн байгууллага, малчдыг оролцуулах олон нийтийн санал санаачилгыг дэмжин ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аймгийн хэмжээнд мал, амьтны сэг зэмийг устгах, орчны цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлийн төлөвлөгөө гаргаж, нэгдсэн удирдамжаар хангах, чанар аюулгүйн шаардлага хангасан ариутгал халдваргүйтгэлийн бодис, биобэлдмэлийн нөөц бүрдүүлэн хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т даалгасугай.

4. Ажлын үр дүнг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аймгийн удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 25-ны өдрийн 10 дүгээр  
захирамжийн хавсралт

**МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМИЙГ ЦУГЛУУЛЖ УСТГАХ, ОРЧНЫ  
ЦЭВЭРЛЭГЭЭ ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго:

Хүн, малын халдварт, гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн улмаас зүй бусаар хорогдсон малын хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, худаг, уст цэг, гол горхи, булаг шанд, бэлчээрийг цэвэрлэж, халдваргүйтгэх ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр. Хугацаа:

Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг, сумын түвшинд зохион байгуулж ажиллах;

Гурав. Хэрэгжүүлэх бүрэлдэхүүн:

Аймгийн түвшинд: Мал эмнэлгийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар,

Сумын түвшинд: Засаг даргын тамгын газар, багийн Засаг дарга нар, Хот тохижилт, үйлчилгээний газар, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран гүйцэтгэнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1. Хүн, малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг, зэмийг устгах, цэвэрлэгээ халдваргүйтгэл хийх "Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн аян"-ыг зохион байгуулж, мэргэжлийн нэгдсэн удирдлага, заавар, зөвлөмжөөр хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.2. Сум бүрд сэг зэм устгалын байршлыг тогтоох;

4.3. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгахад оролцох ажиллах хүн хүч, унаа, тээврийн хэрэгсэл, шаардагдах халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэж, уг ажилд төрийн болон орон нутгийн байгууллага, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр татан оролцуулах;

4.4. Сэг зэм устгах, халдваргүйтгэлийн арга хэмжээнд Монгол Улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, хүн, малын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй халдваргүйтгэлийн бодис хэрэглэх;

4.5. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Мал, амьтны хүүр, сэг зэм устгах үйл ажиллагааны заавар", "Мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэхэд тавих ерөнхий шаардлага" MNS 6406:2013 стандартыг мөрдүүлэн ажиллах;

4.6. Мал, амьтны сэг зэмийн устгал, халдваргүйтгэлийн ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах;

4.7. Мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэлийн ажилд оролцогчдод хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч халдвар хамгааллын дэглэм, журам, зааварчилгааг баримтлан ажиллах;

4.9. Хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийн устгал, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн явцын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдрийн 15:00 цагт багтаан Мал эмнэлгийн газарт ирүүлэх;

Тав. Тайлагналт:

5.1. Мал, амьтны сэг зэмийн устгалын ажлын тайланг фото зургаар баталгаажуулан файл хэлбэрээр 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Мал эмнэлгийн газарт ирүүлэх;

5.2. Сумдын мэдээллийг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэх;